МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр Дугаар А/116 Алтай хот

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 59 дүгээр тогтоолоор баталсан орон нутгийн өмчит 5 байгууллагын таван барилгыг, газар эзэмших эрхийн хамт 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Өмчийн төлөөлөгч: | Ж.Билэгсайхан | (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн) |
| Хөтлөгч: | Б.Балдорж | (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн) |
| Тэмдэглэл хөтлөгч: | Б.Нансалмаа | (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн) |
| Гишүүн: | Б.Золжаргал | (Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | Г.Хурцгэрэл | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | Д.Үлэмжбаяр | (Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын тасгийн дарга, дэд хурандаа) |
| | Д.Ундрахбаяр | (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн) |

2.Нээлттэй дуудлагын худалдаа хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Ж.Билэгсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/-3A-4 doc

0201300446

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 27-ны өдрийн А/113 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Хариуцан хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|
| | Нэг.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр: | | | | |
| 1.1 | АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэж ажиллана | 3-12 сар | Түгээсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагын тоо, давтамж, авсан хандалтын тоо | 10-аас доошгүй шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг 3-аас доошгүй давтамжтай түгээж, тодорхой түвшинд хандалт авсан байна. (Баримтжуулсан байх-Үр дүнг тооцож, тайлагнасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 1.2 | Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулна. | 3-12 сар | Зохион байгуулсан Соён гэгээрүүлэх арга хэмжээний тоо | 2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. (Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 1.3 | Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс. хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбартай болж, ажиллуулна. | 3-12 сар | Мэдээллийн самбартай болсон эсэх | Мэдээллийн самбартай болж, сар бүр мэдээллийг шинэчилж ажиллана. (Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 1.4 | Эрхлэх асуудлын хүрээнд байгууллагынхаа үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэж ажиллана. | 3-12 сар | Бэлтгэж түгээсэн сурталчилгааны материалын тоо | 2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулан бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байна. | Бүх шатны төрийн байгууллага |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Сурталчилгааны материалд авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байна. | |
| Хоёр Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах чиглэлээр: | | | | | |
| 2.1 | Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулна. | 3-12 сар | Шинээр томилогдсон албан хаагчдыг сургалтад хамруулсан эсэх | Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байна. (Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 2.2 | Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах ажлыг зохион байгуулна. | 3-12 сар | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулж, сурталчилсан байна. (Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох чиглэлээр: | | | | | |
| 3.1 | Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх заалт тусгана. | 3-12 сар | Гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан эсэх | Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх, авлигыг мэдээлэх үүргийг тусгаж, гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулсан байна. (Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 3.2 | "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангана. | 3-12 сар | Журмыг хэрэгжүүлсэн эсэх | Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлж, сургалт, хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэн тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байна. | Бүх шатны төрийн байгууллага |
| Дөрөв.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах чиглэлээр: | | | | | |
| 4.1 | Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м) | 3-12 сар | Эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан эсэх | Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна. (Үр дүнг тооцсон байх-Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 4.2 | Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгаж ажиллана. | 3-12 сар | Хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, арга хэмжээ авсан эсэх | 2-оос доошгүй хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулан эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна. | Бүх шатны төрийн байгууллага |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | (Үр дүнг тооцсон байх-Тайланд нотломжийг хавсаргасан байх) | |
| 4.3 | Байгууллагын авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулж ажиллана. | 3-12 сар | Судалгаа авч, арга хэмжээ зохион байгуулсан эсэх | Улирал тутамд судалгаа авч, үр дүнд суурилсан арга хэмжээ хэрэгжүүлж, бодитой үр дүнг тооцсон байна (Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| Тав.Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх чиглэлээр: | | | | | |
| 5.1 | Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах. | 3-12 сар | Хэрэгжүүлсэн эсэх | Танилцуулах арга хэмжээг зохион байгуулж, албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцэн хэрэгжүүлсэн байна. (Арга хэмжээнд удирдлагын - Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 5.2 | Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал зөвлөмжийг тусгаж хэрэгжүүлнэ. | 3-12 сар | Саналыг тусгасан эсэх | Санал тусгасан байна. (Тайланд нотломжийг хавсаргасан байх) | Бүх шатны төрийн байгууллага |
| 5.3 | Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж байгууллагын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, тайлагнан ажиллана. | 3-12 сар | Байгууллагын төлөвлөгөө батлаж, хэрэгжүүлсэн эсэх | Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байна | Бүх шатны төрийн байгууллага |
| Зургаа.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх бусад чиглэлээр: | | | | | |
| 6.1 | Сул орон тоо гарсан тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлж, хууль тогтоомжийн хүрээнд нөхөн томилж ажиллана. | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Хуулийн хэрэгжилт хангагдаж, зөрчил гараагүй байна. | Бүх шатны төрийн байгууллага |
| 6.2 | ХАСУМ гаргах албан тушаалд томилох, шилжүүлэх, сэлгэх, албан тушаал бууруулах тухай бүр мэдүүлгийг хянуулж, ХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулж ажиллана. | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Хуулийн хэрэгжилт хангагдаж, зөрчил гараагүй байна. | Бүх шатны төрийн байгууллага |
| 6.3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 3-12 сар | Хуулийн хэрэгжилтийн хувь | 90-ээс дээш | Бүх шатны төрийн байгууллага |
| 6.4 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллана. | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Хуулийн хэрэгжилт хангагдаж, гэмт хэрэг, зөрчил гараагүй байна. | Бүх шатны төрийн байгууллага |
| 6.5 | Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллана. | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Хуулийн хэрэгжилт хангагдаж, зөрчил гараагүй байна. | Бүх шатны төрийн байгууллага |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6.6 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг ил тод мэдээлж, шийдвэрлэлтийн үр дүнг дээшлүүлж ажиллана. | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Хуулийн хэрэгжилт хангагдаж, өргөдөл гомдлын тоо буурна. | Бүх шатны төрийн байгууллага |
| 6.7 | Албан хаагчдад захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох, худалдан авах ажиллагаанд оролцож буй болон үнэлгээний хороонд ажиллахаас өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулж хэвшүүлнэ. | 3-12 сар | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргуулсан эсэх | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулж, цахим системд бүртгэсэн байна. | Бүх шатны төрийн байгууллага |
| 6.8 | Үйл ажиллагаандаа шуурхай байдлыг эрхэмлэж, хугацаатай албан бичгийн хариу хүргүүлэх, аливаа зөвшөөрөл олгох, төсөв, гүйцэтгэл хянах, өргөдөл гомдол шийдвэрлэхэд ажлын 3 хоногоос хэтрүүлэхгүй байх хугацааг баримтлан хэвшүүлнэ. | 3-12 сар | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 3 хоног | Бүх шатны төрийн байгууллага |

__oOo__

Аймгийн Засаг даргын 20.23 оны
..02. дугаар сарын .27.-ны өдрийн .#113. дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

# ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх хуулийн заалт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтод түвшин, хүрэх үр дүн | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| Нэг.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн хүрээнд: | | | | | | |
| 1 | 27.1.1.хариуцсан чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, иргэдэд хуулийг сахин биелүүлэх дадал бий болгоход чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | Эрхлэх асуудлынхаа хүрээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд сурталчилж, таниулах ажил зохион байгуулна. | 3-11 сар | Зохион байгуулсан ажил, хамруулсан хүний тоо | 5-аас доошгүй ажил зохион байгуулж, 1500-аас доошгүй хүнийг хамруулсан байна. | Бүх шатны төрийн байгууллагууд |
| 2 | | Эрхлэх асуудлынхаа хүрээнд мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг цахимаар сурталчилна. | 3-11 сар | Цахимаар сурталчилсан хууль тогтоомж, хандалтын тоо | 5-аас доошгүйхууль сурталчилж, 1500-аас доошгүй хүний хандалт авсан байна. | Бүх шатны төрийн байгууллагууд |
| 3 | | Байгууллагын албан хаагчдыг гэмт хэрэг, зөрчил гаргах, холбогдохоос урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулна. | 3-12 сар | Зохион байгуулсан ажлын тоо | 2-оос доошгүй | Төрийн бүх шатны байгууллага. |
| 4 | 27.1.2.хуульд заасан эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад байгууллагад дэмжлэг үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, хамтран ажиллах; | Хариуцсан чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бусад байгууллагатай хамтран ажиллана. | 3-12 сар | Хамтран ажилласан ажлын тоо | 2-оос доошгүй | Бүх шатны төрийн байгууллагууд |
| 5 | 27.1.3.эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, | Эрхлэх асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, | 3-12 сар | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 90-ээс доошгүй | Бүх шатны төрийн байгууллагууд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах; | урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлаж, хэрэгжүүлнэ. | | | | |
| 6 | 27.1.4.эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчил гарч байгаа шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгах тухай мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих; | Эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэг, зөрчлийн судалгаа хийж, гарч байгаа шалтгаан, нөхцөл, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгах ажил зохион байгуулна. | 3-12 сар | Зохион байгуулсан ажлын тоо | 2-оос доошгүй | Бүх шатны төрийн байгууллагууд |
| 7 | | Байгууллагын албан хаагчид ажлын өдөр, ажлын цагаар архи, согтууруулах ундаа хэрэглэж гэмт, хэрэг, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулна. | 3-12 сар | Албан хаагч архи, согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх | албан хаагчид ажлын өдөр, ажлын цагаар архи, согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчл гараагүй байна. | Бүх шатны төрийн байгууллагууд |
| Хоёр.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн хүрээнд: | | | | | | |
| 8 | 28.1.1.нутгийн захиргааны бүх шатны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах; | Сумын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 3-12 сар | Холбогдох ажлын хэрэгжилтийн хувь | 90-ээс доошгүй | Сумдын Засаг дарга, |
| 9 | 28.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх; | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардалд өөрийн төсвөөс тодорхой хэмжээнд зарцуулж ажиллана. | 3-12 сар | Зарцуулсан санхүүжилтийн хэмжээ | Тодорхой хэмжээнд хөрөнгө зарцуулсан байна. | Сумдын Засаг дарга, агентлагийн дарга нар |
| 10 | 28.1.5.харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэл өгөх; | Бүх багийн иргэдийн Нийтийн Хурлаар гарсан гэмт хэрэг, зөрчлийн мэдээ, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийж ажиллана. | 3-12 сар | Мэдээлэл хийсэн тоо | 3-аас доошгүй | Сумдын Засаг дарга нар |
| 11 | 28.1.7.нутаг дэвсгэртээ бүртгэгдсэн | Сар бүр гарсан гэмт, хэрэг | 3-12 сар | Зохион байгуулсан | Сард 2-оос доошгүй | Сумдын Засаг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүгнэлт хийж, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач, шинжээчтэй хамтран ажиллах; | зөрчлийн дунд үндэслэсэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | | ажлын тоо | | дарга нар |
| 12 | 28.1.8.ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай ажилласан хуулийн этгээд, иргэний үйл ажиллагааг дэмжих; | Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр ажил зохион байгуулна. | 3-12 сар | Зохион байгуулсан ажлын тоо | 2-оос доошгүй | Сумдын Засаг дарга нар |
| 13 | 28.1.10.хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого баримтлах; | Хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 1.2, Засгийн газрын ерөнхий хууль 4.2 дахь хэсэгт заасан үндсэн болон тусгай зарчмыг мөрдөж ажиллана. | 3-12 сар | Хууль тогтоомж зөрчсөн эсэх | Үйл ажиллагаа, гарсан шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна. | Бүх шатны төрийн байгууллагууд |
| 14 | | Хууль тогтоомжид заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхээр гаргасан захирамж, шийдвэрийг Хууль, эрх зүйн хэлтэст хянуулж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлнэ. | 3-12 сар | Хууль тогтоомж зөрчсөн эсэх | Үйл ажиллагаа, гарсан шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна. | Сумдын Засаг дарга нар |
| 15 | 28.1.11.харьяа нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага, ажиллах цагийн хуваарийг аймаг, нийслэлийн Засаг дарга баталж, мөрдүүлэх; | Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага, ажиллах цагийн хуваарийг батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлнэ. | 3-6 сар | Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн эсэх | Улсын нэгдсэн санд бүртгүүлсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 16 | 28.1.12.харьяа нутаг дэвсгэрийн | Согтууруулах ундаа | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт | Хуулийн хэрэгжилт | Цагдаагийн газар, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэх, худалдах, түгээр үйлчлэх болон мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодисыг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавих; | үйлдвэрлэх, худалдах, түгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих | | хангагдсан эсэх | хангагдана | сумдын Засаг дарга нар, |
| 17 | | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг сурталчилж, хэрэгжилтэд хяналт тавина | 3-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдсан эсэх | Хуулийн хэрэгжилт хангагдана | Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нар, |
| 18 | 28.1.13.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх; | Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан, гэмт хэрэгт холбогдож байсан хүний судалгаа гаргаж, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хяналт тавих | 3-12 сар | Судалгаа гаргасан эсэх | Судалгаа гаргасан байна. | Сумдын Засаг дарга нар |
| 19 | | Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлж ажиллана. | 3-12 сар | Зохион байгуулсан ажлын тоо | 2-оос доошгүй | Сумдын Засаг дарга нар |
| 20 | 28.1.14.нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор олон нийтийн байцаагч томилон ажиллуулах; | Олон нийтийн цагдаагийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хамтран ажиллана. | 3-12 сар | Хамтарч зохион байгуулсан ажлын тоо | 2-оос доошгүй | Сумдын Засаг дарга нар |

__oOo__

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 27-ны өдрийн А/115 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Сурталчлах хууль тогтоомжийн нэр | Зохион байгуулах үйл ажиллагаа | Хугацаа | Хүрэх үр дүн | Хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэгч |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль | Улирал тутамд сумдын сургууль, цэцэрлэгийн багш нарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд сумдаар тойрч багш, ажилчдад хууль тогтоомжийг сурталчлан таниулна. | 1-12 сар | 700-аас доошгүй багш, ажилчдад сургалт явуулсан байна. | Боловсрол шинжлэх ухааны газар | Сургууль, цэцэрлэгүүд |
| 2 | | Сурталчилгааны материал, гарын авлага, цахим ном, зурагт хуудас, цахим хуудас болон нийгмийн сүлжээн дээрх контент, шторк зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна. | 3-12 сар | 10-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж, 5000-аас доошгүй хүнд тухай бүрд нь хүргэсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Бүх шатны төрийн байгууллагууд |
| 3 | Газрын тухай хууль | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас бэлтгэсэн цахим ном, сурталчилгаа, контент, гарын авлага зэрэг хэлбэрээр иргэд, олон нийтэд түгээнэ. | 3-12 сар | Сард 2-аас доошгүй түгээх ажил хийж, жилд 5000-аас доошгүй хүнд хүргэсэн байна. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | Төрийн байгууллагууд |
| 4 | | Дараах хуулийн төслийг иргэд олон нийтэд танилцуулж, санал асуулга авна. Үүнд:<br>1.Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>2.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн | 3 сар | Олон нийтээс санал авч УИХ-ын Тамгын газарт саналыг нэгтгэн хүргүүлсэн байна. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | Сумын Засаг дарга, Газрын даамал |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчилсэн найруулгын төсөл<br>3.Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>4.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хууль<br>5 Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>6.Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл<br>7.Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл | | | | |
| 5 | Зөвшөөрлийн тухай хууль | Зөвшөөрлийн тухай хуулийг сурталчилж, иргэд олон нийтэд түгээх олон талт арга хэмжээ авна. | 1-12 сар | Хуулийн хэрэгжилт хангагдаж, 5000-аас доошгүй хүнд сурталчилсан байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Сум, агентлагийн дарга нар |
| 6 | | Цахим хуудас нийгмийн сүлжээгээр зурагт хуудас, контент, сурталчилгаа зэрэг боломжтой хэлбэрээр олон нийтэд түгээнэ. | | 10-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж, 5000-аас доошгүй хүнд хүргэсэн байна. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | Сумдын Засаг дарга нар |
| 7 | Хот байгуулалтын тухай хууль | Газрын харилцаа-цахим шилжилтийн хүрээнд хууль тогтоомжийг сурталчилна. | 6 сар | 2000-аас доошгүй хүнд сурталчилсан байна. | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар | Сумдын Засаг дарга нар |
| 8 | Хүүхдийн эрхийн тухай хууль | Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний арга хэмжээ зохион байгуулна. | 1-12 сар | 2000-аас доошгүй хүнд сурталчилсан байна. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Сумдын хамтарсан баг, сургуулиуд |
| 9 | Гэр бүлийн тухай | Хамтарсан багийн гишүүдийн чадавхжуулах сургалтыг зохион | 3 сар | 100-аас доошгүй хүнд сургалт | Гэр бүл, хүүхэд, | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулна. | | хийсэн байна. | залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар | |
| 10 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль | Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулна. | 1-12 сар | Сургалтад нийт өрхийн 40 хувийг хамруулсан байна. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Эрүүл мэндийн газар. Соёл урлагийн газар. Насан туршийн боловсролын төв |
| 11 | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль | Залуучуудын сарын аяныг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна | 8 сар | Сарын аяныг зохион байгуулсан байна. | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Насан туршийн боловсролын төв |
| 12 | | Есөнбулаг сумын ажил олгогч, албан журмын даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэдгээрийн өөрчлөлтийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулна. | 1-12 сар | Нийт ажил олгогчдын 70-аас доошгүй хувьд сургалт хийсэн байна. | Нийгмийн даатгалын хэлтэс | - |
| 13 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж | Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдыг сайн дурын даатгалд хамруулах "Даатгалтай ирээдүй " сургалт, өдөрлөг зохион байгуулна. | 7-9 сар | МСҮТ, АШУИС, ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын 80-аас доошгүй хувийг хамруулсан байна. | Нийгмийн даатгалын хэлтэс | - |
| 14 | | Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлт, цахим үйлчилгээний талаар сургалт хийх | 1-12 сар | Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа нийт 300 ажил олгогчид хууль тогтоомжийн | Нийгмийн даатгалын хэлтэс | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | чиглэлээр сургалт хийсэн байна. | | |
| 15 | | "Шинэ-Алтай худалдааны төв", Шилэн зах. томоохон худалдааны төвүүд, иргэдэд мэдээлэл хийж, санал хүсэлтийг хүлээн авах, сургалт, сурталчилгааны материал тарааж ажиллана. | 1-12 сар | 1000-аас доошгүй иргэд, даатгуулагчдыг хамруулсан байна. | Нийгмийн даатгалын хэлтэс | - |
| 16 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль | Холбогдох хууль, журам, тогтоол шийдвэрийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна. | 1-6 сар | 10-аас доошгүй удаа сурталчилж 1000-аас хүнд хүргэсэн байна. | Орон нутгийн өмчийн газар | - |
| 17 | | Худалдан авах ажиллагааны цахим систем ашиглалтын талаар болон холбогдох хууль эрх зүйн талаарх сургалт зохион байгуулна. | 1-12 сар | Сургалтад 100-аас доошгүй төрийн албан хаагчид хамрагдсан байна | Орон нутгийн өмчийн газар | - |
| 18 | Хэмжил зүйн тухай хууль | Хэмжлийн 5 төрлөөр хамтран ажилладаг аж ахуй нэгж байгууллагуудын дунд сургалт зохион байгуулж, дэлхийн хэмжил зүйн өдрийг тэмдэглэн өнгөрүүлнэ. | 5-10 сар | 200-аас доошгүй хүнд хууль сурталчилж, 15 байгууллагыг хамарсан арга хэмжээ зохион байгуулна. | Стандарт, хэмжил зүйн хэлтэс | Дашваанжил ХХК |
| 19 | Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд хууль сурталчилж ажиллана. | 4-11 сар | Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 150 хүн хамрагдсан байна. | Стандарт, хэмжил зүйн хэлтэс | Төрийн байгууллагууд |
| 20 | Татварын ерөнхий хууль | Иргэн, аж ахуй нэгжид хуулийн талаар товч мэдээлэл бүхий видео, шторкыг хэвлэл мэдээллийн хэлтсээр сурталчилна. | 4-12 сар | 1000-аас доошгүй хүнд хүрсэн байна. | Татварын хэлтэс | Сумдын Засаг дарга нар |
| 21 | Хувь хүний орлогын албан татварын тухай хууль | Хувь хүний орлогын албан татварын талаар болон хөнгөлөлт, чөлөөлөлтөд хэрхэн хамрагдах | 4-12 сар | 1000-аас доошгүй хүнд хүрсэн байна. | Татварын хэлтэс | Сумдын Засаг дарга нар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | **талаар гарын авлага бэлтгэн тараах, хэвлэл мэдээллийн** хэрэгслээр сурталчилна. | | | | |
| 22 | Зөрчлийн тухай хууль | Татвар төлөгч нарт хуулийн хариуцлагын талаар сургалт зохион байгуулах, цахим мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийнэ. | 4-12 сар | 1000-аас доошгүй хүнд хүрсэн байна. | Татварын хэлтэс | Сумдын Засаг дарга нар |
| 23 | | Төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулна. ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн сурталчилгааны материал, шторк, контент, зурагт хуудас мэдээллийг иргэд олон нийтэд түгээнэ | 9- 12 сар | Сургалтад 250-аас доошгүй төрийн албан хаагчийг хамруулсан байна. Сард 2-оос доошгүй түгээх ажлыг хийж, жилд 5000-аас доошгүй хүний хандалт авсан байна | Цагдаагийн газар | Прокурорын газар |
| 24 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль | НӨАТ-ын хуулийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг иргэн, аж ахуй нэгж байгууллагад сургалт зохион байгуулан хүргэнэ. | 4-12 сар | 100-аас доошгүй хүнд сургалт хийсэн байна. | Татварын хэлтэс | Сумдын Засаг дарга нар |
| 25 | Малын тоо толгойн албан татварын тухай хууль, тогтоомж | Малчин, мал бүхий этгээдэд сургалт хийнэ. | 4-12 сар | 100-аас доошгүй хүнд сургалт хийсэн байна. | Татварын хэлтэс | Сумдын Засаг дарга нар |
| 26 | | Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийнэ. | 6-7 сар | Орон нутгийн Алтай радиогоор 3-аас доошгүй удаа хуулийн сурталчилгаа хийсэн байна | Хүнс, хөдөө аж ахуйн газар | Татварын хэлтэс |
| 27 | Цахим хөгжлийн багц хуулиуд | Хууль тогтоомжоор зурагт хуудас мэдээлэл бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр | 2-9 сар | 500-аас доошгүй хүнд сурталчилсан | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Сумдын Засаг дарга нар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчилна. | | байна. | | |
| 28 | Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбогдох хууль тогтоомж | Төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулна. | 3-5 сар | 100-аас доошгүй албан хаагчид сургалт хийсэн байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Төрийн албаны салбар зөвлөл |
| 29 | Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль | Байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулах | 5 сар | Сургалтад 30-аас доошгүй ажилчдыг хамруулсан байна | Ус, цаг уур, орчны шинжилгээний төв | Аймгийн Засаг даргын Тамгын газар |
| 30 | Хөдөлмөрийн тухай хууль | Ерөнхий боловсролын сургууль ,цэцэрлэгийн ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулна. | 2 сар | 400-аас доошгүй гарын авлага тарааж, 200-аас доошгүй хүнд сургалт хийсэн байна. | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар | Төрийн байгууллагууд |
| 31 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд хууль сурталчлах өдөрлөг зохион байгуулна. | 4-5 сар | 800-аас доошгүй гарын авлага тарааж, 2000-аас доошгүй иргэнийг хамруулсан байна | Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл |
| 32 | "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх хяналт тавих журам" | Сургалт хийж, гарын авлага тараана. | 3-5 сар | 2-доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Хүнс, хөдөө аж ахуйн газар | Сумын Засаг дарга нар |
| 33 | "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам" | Сургалт хийж, гарын авлага тараана. | 2-12 сар | Сум тус бүр 1 удаа сургалт зохион байгуулсан байна. | Хүнс, хөдөө аж ахуйн газар | Төрийн байгууллагууд |
| 34 | Засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолын хүрээнд "Хонь, тэмээний | Хонь, тэмээний ноосны урамшуулалд хамрагдах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр | 6-7 сар | Орон нутгийн Алтай радиогоор 3 минутын 2 | Хүнс, хөдөө аж ахуйн газар | Орон нутгийн Алтай радио |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ноос бэлтгэж, үндэсний **үйлдвэрт** тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам"; | малчдад мэдээлэл өгнө. | | удаагийн сурталчилгааг хийсэн байна. | | |
| 35 | Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар "Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам | Арьс ширний урамшуулалд хамрагдах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр малчдад мэдээлэл өгнө. | 10-11 сар | Орон нутгийн Алтай радиогоор 3 минутын 2 удаагийн сурталчилгааг хийсэн байна. | Хүнс, хөдөө аж ахуйн газар | Орон нутгийн Алтай радио |
| 36 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих архидан согтуурахтай тэмцэх тухай хууль | Хууль тогтоомжоор зурагт хуудас хийж **хэвлэл** мэдээллийн хэрэгслээр сурталчилж, төрийн албан **хаагчдад сургалт** зохион байгуулан, ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн сурталчилгааны материал, шторк, **контент**, зурагт хуудас мэдээллийг иргэд олон нийтэд түгээнэ. | 3-12 сар | 10-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж, 5000-аас доошгүй хүнд хүргэсэн байна. Сургалтад 250-аас доошгүй төрийн албан хаагчийг хамруулсан байна. | Цагдаагийн газар | Прокурорын газар |
| 37 | Эрүүгийн хууль холбогдох заалт /ХЭМХБЭГХ Залилах гэмт хэрэг, Хулгайлах гэмт хэрэг | ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн сурталчилгааны материал, шторк, **контент**, зурагт хуудас мэдээллийг иргэд олон нийтэд түгээнэ | 3-12 сар | 10-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж, 5000-аас доошгүй хүнд хүргэсэн байна Сургалтад 250-аас доошгүй төрийн албан хаагчийг хамруулсан байн. | Цагдаагийн газар | Прокурорын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 38 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль | Хуулийг сурталчилна. | 5 сар | **500-аас доошгүй хүнд** сурталчилсан байна. | **Шүүхийн** шийдвэр гүйцэтгэх газар | **Төрийн** байгууллагууд |
| 39 | "Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль" /ЗГ-ын МХ-ийн 4.4.5/ | Төрийн алба хаагчдад сурталчилна. | 4 сар | 100-аас доошгүй хүнд сурталчилсан байна. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | Прокурорын байгууллага |
| 40 | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах /АХ 2050-ийн 7.4.3, ШШГТХ/ | Хорихоос өөр төрлийн ял. албадлагын арга хэмжээний талаар иргэдэд мэдээлэл өгнө | 8 сар | 500-аас доошгүй хүнд мэдээлэл өгсөн байна. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | Хорих өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан тасаг |
| 41 | **Шүүх** шинжилгээний тухай хууль | Хууль тогтоомжоор гарын авлага гаргаж иргэдэд тараах, хамтран ажилладаг байгууллагат хүргүүлэх | 4 сар | 500 ширхэгийг тараасан байна | Шүүхийн шинжилгээний хэлтэс | - |
| 42 | | Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж иргэдэд мэдээлэл өгнө. | 5-10 сар | 100 иргэнд мэдээлэл хийсэн байна | Шүүхийн шинжилгээний хэлтэс | - |
| 43 | | Цагдаа, прокурор, шүүхийн байгууллагатай хамтарсан зөвлөгөөн хийнэ | 5-11 сар | Хамтран **ажилладаг** байгууллагуудад мэдээлэл хийсэн байна | Шүүхийн шинжилгээний хэлтэс | - |
| 44 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль | Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоол, тушаал, журмыг иргэдэд болон эрүүл мэндийн байгууллагуудад сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулна. | 3-12 сар | Иргэд даатгуулагч нарт жилд 2000-аас дээш хүнийг хамруулсан байна. Гэрээт байгууллагат 3-4 удаа сургалт сурталчилгаа цахим хэлбэрээр түгээсэн байна | Эрүүл мэндийн даатгалын хэлтэс | Гэрээт 67 байгууллага, иргэд даатгуулагч нарт |
| 45 | Эрүүл мэндийн даатгалын | Даатгуулагчийн эрх болон эрүүл | 1-12 сар | 20-аас доошгүй | Эрүүл мэндийн | **Иргэд** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тухай | мэндийн туслампж үйлчилгээг авах боломжийн талаарх мэдээ, мэдээллийг зурагт постер, хөдөлгөөнт постер, лайв, видео хэлбэрээр олон нийтэд хүргэнэ. | | сурталчилгааны зурагт постер, 1000-аас доошгүй хүнд хүргэсэн байна. | даатгалын хэлтэс | даатгуулагчид |
| 46 | | Хууль тогтоомжийн хүрээнд танилцуулга мэдээлэл бэлтгэж цахим хуудсаар сурталчилна. Үйлчлүүлэгчид ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулна. Эрүүл мэндийн газраас бэлтгэсэн сурталчилгааны материал шторк, контент, зурагт хуудас, мэдээллийг иргэд олон нийтэд түгээнэ. | 2-12 сар | 5-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж, 200-аас доошгүй хүнд хүргэсэн байна Сард 2-аас доошгүй цахим сурталчилгаа хийж, жилд 3000-аас доошгүй хандалт авсан байна | Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар | Эрүүл мэндийн газар |
| 47 | Галын аюулгүй байдлын тухай хууль | Хууль тогтоомжоор зурагт хуудас, мэдээлэл бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчдад танхимын сургалт зохион байгуулах, Онцгой байдлын ерөнхий газраас бэлтгэн гаргасан шторк, зурагт хуудас, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээх ажлыг хийнэ. | 1-12 сар | 500-аас доошгүй хүнийг хамруулсан байна. | Онцгой байдлын газар | Сумдын Засаг даргын Тамгын газар |
| 48 | Гамшгаас хамгаалах тухай хууль | Хууль тогтоомжоор зурагт хуудас, мэдээлэл бэлтгэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчдад танхимын сургалт зохион байгуулах, Онцгой байдлын ерөнхий газраас бэлтгэн гаргасан | 1-12 сар | 500-аас доошгүй хүнийг хамруулсан байна. | Онцгой байдлын газар | Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шторк, зурагт хуудас, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээх ажлыг хийнэ. | | | |
| 49 | Ойн тухай хууль | Ойн тухай хууль, ойн цэвэрлэгээ хийх дүрэм, журмыг олон нийтэд сурталчилна. | 1-12 сар | Жилд 2-оос доошгүй удаа сурталчилсан байна. | Сум дундын ойн анги | Сумдын Засаг даргын Тамгын газар |
| 50 | Байгалийн нөөц ашиглалт төлбөрийн орлогын бүрдүүлэлт Засгийн газрын 2 дугаар тогтоол | Сумдын ИТХ-ын төлөөлөгч нарт төлөвлөх зарцуулах чиглэлээр сургалт зохион байгуулна | 3-5 сар | 250-аас доошгүй албан хаагчийг хамруулсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл |
| 51 | | БОХУБ, байгаль хамгаалагч нарт программын чиглэлээр сургалт зохион байгуулна. | 6-7 сар | 18 сумын 41 албан хаагчийг хамруулсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Сумдын Засаг даргын Тамгын газар |
| 52 | | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого төлөлт, барагдуулах чиглэлээр зурагт хуудас, мэдээлэл бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна. | 9-10 сар | 3-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж цахимаар сурталчилсан байна. | Байгаль орчин, аялал жуулчлалын газар | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| 53 | Шинээр болон өөрчлөн батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль, тогтоомж | Шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг талаар зурагт хуудас мэдээлэл бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах. Төрийн байгууллага, иргэдэд танхимын болон цахим сургалт зохион байгуулж иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ. | 3-12 сар | 1000-аас доошгүй хүнд сургалт зохион байгуулсан байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Төрийн байгууллагууд |
| 54 | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Өрсөлдөөний тухай хууль | Шударга өрсөлдөөнийг бий болгох ажлын төлөвлөгөө батлуулж тус хуулиудаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | 3-12 сар | 5-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж 2000-аас доошгүй хүнд сургалт зохион байгуулсан байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Төрийн байгууллагууд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 55 | Хүний эрхтэй холбогдох хууль тогтоомж | Хүнийг эрхийг хангах, хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | 3-12 сар | 15-аас доошгүй сурталчилгааны материал бэлтгэн түгээж 2000-аас доошгүй хүнд сургалт зохион байгуулсан байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Төрийн байгууллагууд |
| 56 | Нотариатын тухай хууль | Нотариатын үүргийг хавсран гүйцэтгэгч нарыг чадавхжуулах сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 3-12 сар | 2-аас доошгүй сургалтад нотариатын үүргийг хавсран гүйцэтгэгч нарыг хамруулсан байна. | Аймгийн Засаг даргын Тамгын газар | Хууль зүй дотоод хэргийн яам, Монголын Нотариатчдын танхим |
| 57 | Цахим гарын үсгийн тухай хууль | Тоон гарын үсгийн ач холбогдол хэрхэн хэрэглэх, хувь хүний нууцад хамааралтай мэдээллийн талаар төрийн байгууллага, иргэдэд танхимын болон цахим сургалт зохион байгуулж тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ. | 3-12 сар | 2000-аас доошгүй хүнд сургалт зохион байгуулсан байна. | Улсын бүртгэлийн хэлтэс | Сумдын Засаг даргын Тамгын газар |
| 58 | Хууль, эрх зүйн мэдлэгтэй болох, иргэдэд түгээх | Хууль тогтоомжийг судлах, ойлгох, хэрэгжүүлэх ажлыг төрийн албан хаагчид бүр үндсэн үүргээ болгох. Хууль тогтоомжуудаар сар бүр "АХА" тэмцээн, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж хэвших, иргэдийн дунд хууль тогтоомжийн мэдлэг, хэрэгжилтэд судалгаа авч үнэлэлт дүгнэлт өгч ажиллах. | 3-12 | Төрийн албан хаагч бүр 10-аас доошгүй хууль судалсан байх, 5-аас доошгүй "АХА" тэмцээн зохион байгуулж 300-аас доошгүй иргэдээс судалгаа авсан байна. | Төрийн байгууллагууд | - |

---oOo---